

## ЛУ СИНЬ БОЛ ХЯТАДЫН ХУВЬСГАЛТ УТГА ЗОХИОЛЫГ ҮНДЭСЛЭГЧ МӨН

**Д. Маам**

Түүхийн ухааны дэд эрдэмтэн,  
зохиолч

Энэ оны есдүгээр сард дэлхийн соёлт бүх улс түмэн, түүний дотор манай орны олон нийт хятадын хувьсгалт утга зохиолыг үндэслэгч Лу Синий мэндэлсний нэгэн зууны ойг ёслон тэмдэглэв.<sup>1</sup> «Сайн номыг уншиж эхлэхэд сайн нөхөртэй учрахын адил, уншиж суухад сайн нөхөртэй хөөрөлдөхийн адил, уншиж дуусахад сайн нөхрөөс хагацахын адил»<sup>2</sup> гэж ярьдаг хятадын ард түмний төрүүлсэн их зохиолч Лу Синь дэвшилт хүн төрөлхтний сайн нөхөр болсон олон сайн ном зохиол бүтээсэн билээ.

Лу Синий бүтээл туурвилын тухай энэхүү өгүүллийн оршил болгож 1930 оны тавдугаар сард өөрийн нь бичиж хэвлүүлсэн намтрыг үндэслэн их зохиолчийн амьдралын замналаас товч дурдах нь зүйтэй боловч үзлээ. «...Миний эцэг боловсролтой хүн байсан. Харин Лу овогт эх маань тосгоны жирийн эмэгтэй байлаа. Эх маань өөрөө оролдож бичиг сурсан юм...

Манай гэрт гэнэтийн гай зовлон тохиолдож хоосроход би 13 нас хүрч явлаа. Амь зуулгахаар намайг хамаатнууд руугаа явуулсан боловч Тэд: «гуйранч», «ээ, гуйранч!» гэж шоовдорлоод байхлаар нь би гэртээ буцаж ирэв. Эцэг удалгүй бие барлаа. Манайх бүр хоосорч намайг сургуульд суралцуулах ч мөнгөгүй болсон юм...»<sup>3</sup> гэж Лу Синь товч намтраа эхэлсэн байна. Ирээдүйн их зохиолч 18 насандаа Нанкинд очиж далайн дунд сургуулийн механикийн ангид оржээ. Жилийн дараа уул уурхайн дунд сургуулийн ашигт малтмалын ангид шилжин суралцаж төгсөөд Японд явжээ. Лу Синий бичсэн нь: «...Бэлтгэл ангийн дараа өөрийгөө би анагаах ухаанд зориулахаар шийдэв. Орчин үеийн анагаах ухаан нийгмийн шинэчлэлд асар их тус хүргэж болох юм гэдгийг ойлгосон явдал намайг тийм алхам хийлгэж билээ. Би Сэндай хотын анагаахын дээд сургуульд орж хоёр жил суралцлаа. Тэр үед Орос-японы дайн болж байв. Тохиолдлоор дайны сэдэвтэй нэг кино үзэж, тагнуул хийсний учир цаазаар авахуулж байгаа хятад хүнийг тэр киноноос олж харсан маань хэд гуравхан хятадыг эмчилж эдгээгээд ямар ч тус алга гэдэг бодол төрүүлсэн юм. Хятад эх оронд өргөн цараатай хөдөлгөөн хэрэгтэй байв... Эн тэрүүнд шинэ утга зохиолыг дэвшүүлэн гаргаж тавих ёстой байлаа. Би сургуулиа орхиж Токиод буцаж ирэв. Хэдэн залуу нөхөртэй нийлж янз бүрийн төсөл төлөвлөгөө зохиосон боловч амжилт ер олсон үгүй. Герман руу явдаг ч юм билүү гэж бодлоо. Гэвч бас л бүтсэнгүй. Эцсийн эцэст ээж минь, мөн манай гэр бүлийн бусад гишүүд надаас

<sup>1</sup>«Үнэн». 1981 оны IX сарын 26. «Литературная газета» 24 сентября, 1981 г. № 40.

<sup>2</sup>Онч мэргэн үгс, УБ., 1971. 230 дугаар тал.

<sup>3</sup>Лу Синь. Рассказы и статьи. М., 1950. стр 82

мөнгөний тусламж горьдож байгааг бодолцон эх орондоо эргэж харьсан юм. Тэгэхэд би 25 настай байлаа»<sup>4</sup> гэжээ.

Харь оронд сурахаар одоод 25 насандаа сургуулиа ч төгсөлгүй буцаж ирсэн нь хэн нэгэн хүний гайхлыг төрүүлж болох боловч Лу Синь зохиолчийн тэмцлийн яруу замнал чухам энэ үеэс эхэлсэн билээ. Лу Синь мянга гаруй нийтлэл, өгүүлэг, тууж бичиж хэвлүүлсний дотор бүтээл тууривлынхаа сан хөмрөгт 1400 гаруй захидал, 20 жилийн турш уйгагүй хөтөлсөн өдрийн тэмдэглэл үлдээсэн нь 300 гаруй хэвлэлийн хуудас болжээ. Хятадын аугаа их соён гийгүүлэгч тэр хүн гадаадын 14 орны 100 гаруй зохиолчийн бүгд 175 хэвлэлийн хуудас зохиол бүтээлийг хятадаар орчуулжээ.<sup>5</sup>

xx xx xx

Зуун жилийн тэртээ буюу 1881 оны есдүгээр сарын 25-ны өдөр Манж Чин улсын Хятад хязгаарын Жэ Зян мужийн Шао-син тосгонд хоосорсон газрын эзэн Жоу овогтны гэрт төрсөн жирийн нэг хүү Хятадын орчин цагийн хувьсгалт утга зохиолыг үндэслэгч билгийн нүдтэй их бичгийн хүн болсон нь олон зүйл түүхэн шалтгаанаар тайлбарлагдана.

1900 оны ихэтуаньчуудын бослого дарагдаж манжийн 200 жилийн дарлалд хэлмэгдсээр байгаа эх оронд нь найман орны цэрэг эзэрхэн орж ирэхийг нүдээр үзэж, хувьсгалын өрнөлтийн жилүүдийг биеэр туулан, сэтгэл зүрхээрээ хувьсгалыг даган өрнөж явсан нь залуу Лу Синий ертөнцийг үзэх үзэл бүрэлдэхэд чухал үүрэг гүйцэтгэжээ. В. И. Ленин Хятадын нийгмийн хөгжлийн тэр үеийг ангийн тэмцлийн үүднээс авч үзээд «бослого самуун дэгдээх явдлаас ухамсарт ардчилсан хөдөлгөөнд шилжсэн үе» гэж тодорхойлжээ.<sup>6</sup> Лу Синь «Ухамсарт ардчилсан хөдөлгөөний үеийн» хүн байсан төдийгүй, тухайн үеэ бүтээлцсэн хүн байсан юм.

Түүний үзэл санааны төгс бүрдэлд аугаа их Октябрийн социалист хувьсгал шийдвэрлэгч нөлөө үзүүлжээ. Тэгээд ч Лу Синь: «Оросын утга зохиол бидний өмнө дарлагдагчийн сайхан сэтгэл, түүний зовлон зүдгүүр, тэмцэл тулалдааныг нээн үзүүлжээ. Бид хамгийн чухал зүйлийг, тухайлбал ертөнцөд дарлагч, дарлагдагч хоёр анги оршиж буйг энэ уран зохиолоос мэдэрч ойлгосон юм, Энэ нь бидний хувьд хүн төрөлхтөн гал нээж олсонтой жишээлэхүйц тийм нээлт байсан!»<sup>7</sup> гэж бичжээ

Хятадын коммунист, ажилчны хөдөлгөөнтэй ойртон ажилласан нь хүн нийгмийн түүхийг ойлгох оньсон түлхүүр-ангийн тэмцлийн мөн чанарт нэвтрэх замыг Лу Синьд тодруулж өгчээ.

ХКН-ыг үндэслэгчийн нэг Ли Дажао-тай танилцаж «Залуу нас» сэтгүүлд материал нийтлүүлэх зэргээр хамтран ажиллаж байсныг энд дурдаж болно. Коммунист Цюй Цюбогийн тэмдэглэснээр 1911 оны хувьсгалын дараа хятадын нийгмийг чухам хэн ноёрхож байна вэ? гэдэг асуултыг тэр болгон хүн ойлгож чадахгүй байжээ. Гэтэл Лу Синь харгис цөөнхийн ноёрхол тогтсоныг зөв таньж «орчин үеэ яргалагчдын засаг» гэж тодорхойлсон аж.<sup>8</sup> «Одоо цагаа алан хядаж байгаа тэр хүмүүс ирээдүйг ч мөн алан хядах болнс»<sup>9</sup> гэж Лу Синь заасан нь капиталыг шүүмжилж, хөдөлмөрийг өмгөөлж хамгаалсан түүний ангийн байр суурийг тод илтгэж байна.

<sup>4</sup>Мөн тэнд: стр 83.

<sup>5</sup>Информационный бюллетень. Синьхуа 21 сентября 1981 г. № 7403, стр 9,

<sup>6</sup>В. И. Ленин. Соч., т. 15, стр 162.

<sup>7</sup>Л. Д. Позднеева. Лу Синь: жизнь и творчество, М., 1959, стр. 3.

<sup>8</sup>Цюй Цюбо. Луаньтань Зи Цита.

<sup>9</sup>Мөн тэнд.

Чухам хувьсгал гэж юу болох тухайд Лу Синий ойлголтыг авч үзэх нь сонин юм. Их зохиолч 1927 оны дөрөвдүгээр сарын 8-нд Хуанпугийн цэргийн дарга нарын сургуульд уншсан лекцэндээ: «...Анхны нэгэн эст амьтнаас хүн болтол, зэрлэг бүдүүлгээс соёлт боловсронгуйг хүртэл өөрчлөгдсөн нь цөм тасралтгүй үргэлжилсэн хувьсгалын үр дүн билээ. Хувьсгал бол янз янз байхын дээр хачирхам гойд чамин зүйл биш.

Мөхөж сөнөх тавилангүй үндэстэн бүр л хувьсгалыг эрт орой хэзээ боловч хийх ёстой бөгөөд тэр нь том жижиг янз бүр байлаа ч гэсэн хувьсгал гарцаагүй мөн болой»<sup>10</sup> гэж тэмдэглэж байжээ.

Зохиолч дээр өгүүлсэн бүтээлдээ хувьсгалт утга зохиолын талаар онолын гүн үндэслэлтэй, хятадын нийгмийн соёлын түүхэнд өөдрөг шинэ санаануудыг дэвшүүлжээ. «Аугаа их хувьсгал бол уран зохиолын агуулга хэлбэрийг өөрчилж чадна. Харин жижигхэн хувьсгал тиймгүй. Үнэндээ тэр нь хувьсгалын хэмжээ шатанд хүрээгүй хувьсгал учраас тийм өөрчлөлтийг хийж эс чадмуй!»<sup>11</sup> гэж Лу Синь үзэж байлаа. Хувьсгалыг гансралаар хийж болохгүй нь тод боловч хувьсгалын өмнөх аливаа уран зохиолд гаслант дуу хоолой, гиншин ёойлох өнгө аяс сонсогддог гэж Лу Синь тэмдэглэжээ.<sup>12</sup> Гэвч «гаслант дуу хоолой бархируулсан уран зохиол хувьсгалд төдийлөн нөлөөлөхгүй. Учир нь...хулгана хичнээн бархирч бүлтэгнээд ямар ч сайхан зохиол гаргаад ирсэн, муур гуай төдий л ёсорхолгүй хулганыг зооглож орхихтой»<sup>13</sup> энэ нь адил төстэй юм гэж Ли Синь бичсэн байна.

Их зохиолч хувьсгалыг дээд зэргээр мэдэрч ойлгож байсан төдийгүй Максим Горькийг санагдуулам хувьсгалын дууч, уриач байсан нь хувьсгалт уран зохиолын тухай түүний бичсэн дараах мөрүүдээс тод ажиглагдаж байна. «...Египет, Араб, Энэтхэг цөм гасалж гансрахаа зогссон байна. ...Эрчит эсэргүүцэл далдын их нөөц хүчээ илтгэн хувьсгалжсан үндэстэн гомдлын дуугаа битүү хилэгнэлийн хүрхрэлт болгон өөрчилдөг жамтай. Уур хилэн нь оволзсон уран зохиол гарч ирмэгц эсэргүүцэн босох явдал төдий чинээ дөхөж... ингэж хилэнгийн оч бадраасан утга зохиол, дүрсхийн шатах хувьсгал хоёр харилцан бие биенээ хөгжөөнө. ...Зөвлөлт Орос оронд хувьсгал дэгдэхийн угтал болж ийм уран зохиол төрж байлаа»<sup>14</sup> гэж Лу Синь утга зохиол ба хувьсгалын шүтэлцээг тодорхойлжээ. Лу Синий энэ үг бол зүгээр нэг утга зохиолын онолчийн үг биш, намч утга зохиолын жинхэнэ дуу хоолой болох нь илэрхий.

Хувьсгалч бичгийн хүний гол шинж чанар бол тэмцэх явдал байдаг. «Үндэстний цэвэр тунгалаг байдал», «үндэстний онцлог байдлыг» хадгалах нэрийн дор харгис хуучинтай зууралдаж, дэвшилттэй шинэ юмс үзэгдлийн хувьсгалжуулах, өөрчлөн, өөд татах нөлөө хүрээг боон хяхагчидтай Лу Синь бүтээлч амьдралынхаа турш зарчимч тэмцэл явуулжээ. «Хэрэв бид үндэстнийхээ цэвэр тунгалаг байдлыг хадгалах хэрэгтэй юм бол, үндэстний маань цэвэр тунгалаг байдал эргээд биднийг хадгалах хэрэгтэй!» гэж тэр бичсэн юм.<sup>15</sup> «Бид» гэдэг үгээр Лу Синь нийгмийн тэргүүний соёл, тэргүүний ухамсарыг илэрхийлж байв. Тэр соёл ухамсарыг хүлээн зөвшөөрөхгүйгээр нийгэм цэвэр тунгалаг байж болохгүй гэдэг санааг зохиолч ийнхүү дэвшүүлжээ.

«Өөрийн юм», «хятадын онцлог» бүхэн хиргүй сайн сайхан байдаг мэтээр нотлогсодод Лу Синь, «ях аргагүй онцлог, яах аргагүй өөрийн

<sup>10</sup> «1927 оныг дөрөвдүгээр сарын 8-нд Хуанпугийн цэргийн дарга нарын сургуульд уншсан лекц». «Мөнх гийгч дэнлүү» УБ. 1954, 54—55 дахь тал

<sup>11</sup> Мөнх гийгч дэнлүү. 54 дахь тал.

<sup>12</sup> Мөн тэнд, 55 дахь тал.

<sup>13</sup> Мөн тэнд.

<sup>14</sup> Мөн тэнд. 55—56 дахь тал.

<sup>15</sup> Л. Д. Позднеева. Лу Синь (жизнь и творчество), М., 1959. с 127.

биен дээр ургасан хорт хавдар бас л хиргүй сайн сайхан зүйл мөн үү?! гэсэн хялбархан хийгээд хүчтэй няцаалт өгсөн юм.<sup>16</sup>

Их зохиолчийн хөдөлмөрийг эсэргүүцэгчид түүний Лу Синьч шинийн эсрэг хуучныг сэргүүлэн тавихдаа «Хятадын соёлын эрдэнэсийн санг хүндэтгэхгүй, гал голомтоо орхиж одсон зуугуур хүн мэт тэр эрдэнэсийн сангаас зугтаалаа...» хэмээн Лу Синийг зэмлэж, үндэстний нэр барин түүнийг гадуурхан шоовдорлохыг оролдож байлаа. Харин Лу Синь үзэл суртлын тийм дайснуудад: «Түрүү үеийн мэргэдийн зохиол бүтээлийг туг болгон өргөх нь дууриавал зохих сайн зүйл мөн боловч заавал хуучин хүрмээ угааж өмсөхгүйгээр шинэ хүрэм оёж өмсөж болно, оёж өмсөх ч хэрэгтэй гэдэгт би итгэнэм»<sup>17</sup> хэмээн ёгтолсон байдаг.

Лу Синий нэгэнтээ бичсэн нь: Хятадын уран зураг ба үргэлжилсэи үгийн зохиолд нийгмийн доод давхаргыг «хаадын буянд булхаж байгаа» жаргалант хүмүүс мэтээр үзүүлж, тэднийг ургах цэцэг, жиргэх шувуу шиг дүрсэлдэг юм.

Би өөрөө хотод өссөний дээр хүүхэд ахуй цагаас хуучин ном зохиолын сурталд айхтар автсан тул хөдөлмөрчин хүмүүсийг мөн л цэцэг, шувуутай адил гэж төсөөлж бодож явлаа.

Харин сүүлд Орос, Польш болон балканы бага орнуудын зохиолчдын номтой танилцаж, дэлхий ертөнцөд манай хүн ард мэт хувь тавилантай ард түмнүүд байдаг хийгээд, тэр байдлыг өөрчлөхийн төлөө тэмцэгч бичгийн хүмүүс байдгийг ойлгосон юм».<sup>18</sup> Ингэж дэлхий дахины дэвшилт соёлтой танилцан нийгэм, эдийн засгийн амьдрал, тэргүүний шинжлэх ухаан хоёрын шүтэлцээг зөв ухаарснаараа Лу Синь өөрийн амьдарч ажиллаж байгаа нийгэмд соёлын хувьсгал хийх ёстой, тэр хувьсгал дарлагдагч олон түмний тусын тулд, тэдний үр хүүхэд, ач, жич нарын тусын тулд байх ёстой гэдгийг ойлгосон байна. Энэ ойлголтоо ажил хэрэг болгоход тэр хүн бүхэл ухамсарт амьдралаа зориулсан хийгээд эцсийн үр дүнд түүний бие хятадын орчин цагийн хувьсгалт утга зохиолын үндсийг нэр төртэйгээр тавьж чаджээ. Зөвлөлтийн эрдэмтдийн үзэж дүгнэж байгаагаар Лу Синь нь XIX зууны сүүлээс XX зууны гучаад оныг хүртэл хятадын нийгмийн шилдэг хүмүүсийн эхний эгнээнд холбиролтгүй явж, нэгэн биеийн бүтээлд хятадын утга зохиолын хөгжлийн бүхэл үеийг тольдон тусгах замаар дээрх гарамгай үйлсийг бүтээсэн аж. Тухайлбал хятадын дундад зууны үеийн шашин-гүн ухааны сэдэв, адал явдлын уран зохиол, хувьсгалт романтизм, шүүмжлэлт реализм энэ бүхэн Лу Синийг дамжсан буюу энэ бүхнийг Лу Синь дамжжээ. Ингэсний эцэст Лу Синь хувьсгалт реализмд хүрсэн байна. Маргаашийн социалист гэрэл гэгээ мэдрэгдэж байдагт нь Лу Синий реализмын хамгийн нандин чанар орших бөгөөд энэ бол түүний уран бүтээлийнхээ эрэл хайгуулын замд байлдан дагуулсан олон оргилын хамгийн өндөр нь болно. «Төрөлх суурин» номондоо түүний бичсэн нь: «Миний зээ хүү над шиг зожиг тэнүүлч хүний золбин амьдралаар битгий амьдраасай. Дорой ядуугаасаа болж зарц тариачин Рун Ту шиг зовлонд битгий өртөөсэй. Чи минь манай үеийн үзээгүй шинэ амьдралаар амьдрах ёстой шүү!» гэжээ.

Шинэ амьдрал хэрхэн цогцлон бүтэж бүрэлдэхийг Рун Туны их анд Лу овогт зохиолч нэвтэрхий харж байв. Тэрвээр Горькийн алдарт «Эх» романы талаар их Лениний «цаг үеэ олсон ном» гэсэн үнэлэлтийг таашаан давтаж, «Миний бодоход зөвхөн тэр үед төдийгүй, одоо ч цаг

<sup>16</sup>Мөн тэнд.

<sup>17</sup>Хятад дахь хэрэг явдал (1963—1973) | боть, УБ., 1974. 270-р тал.

<sup>18</sup>Лу Синь, Полное собрание сочинений, т. 7. с 632, В. И. Семеновын «Лу-Синь и его предшественники» номноос дамжуулж иш татлаа.

үеэ олсон ном хэвээр байна. Хятад орны эдүгээ болон маргаашид ийм л ном тохирохсон» гэж хэлжээ. Мажаарын их яруу найрагч Шаандар Пөтөөфи сайн дураар эрх чөлөөний дайнд явж баатарлагаар амь үрэгдсэнийг жинхэнэ ард түмний зохиолчийн нэр төрийг туг болгож өргөсөн гавъяат үйлс хэмээн Лу Синь бахархан тэмдэглэсэн байдаг.

Ардын амьдралыг ардын өөрийнх нь хэлээр реалист аргаар дүрслэн үзүүлсэнд Лу Синий ардач, шинэчлэгч хоёр гол чанар зэрэгпэн тодорчээ. Тариачны хүүхдүүдтэй хутгалдан, муудалцаж сайдалцаж явахдаа сурсан ардын хятад хэл, хэдийгээр баялаг уламжлалтай боловч хятадын үхмэл хэлтэй зогссонги соёлд хувьсгал хийх зэвсгийг Лу Синьд өгсөн байна.<sup>19</sup>

Лу Синь ихэнх хятадууд бичиг үсэггүй бөгөөд соёлгүй учир бүдүүлэг авиртай, юм мэдэхгүй гэнэхэн байдгийг хүлээн зөвшөөрөөд, «гэвч юм мэдэхгүй гэнэхэн олон түмэнд зориулж тэдний ойлгох ямар нэгэн шинэ хэл «зохиохдоо» бус, «дөрвөн сая хятад хүний ярьж байгаа» тэр хэлийг бичгийн хүрээнд татан оруулж, утга зохиолын амьд хэл бүрдүүлэхэд сэхээтний хувьсгалч мөн чанар, эх оронч үүрэг оршино гэж үзэж байлаа.

Юуны өмнө Лу Синь жирийн ардын амьдралыг тусгасан богино өгүүллэг, далд утгын шогч наргианч авсаархан туужаараа хятадын утга зохиолд, чухам хэрэгтэй байсан шинэчлэлийг хийсэн гэдэгт олон орны Лу Синь судлаачдын санал нэгэн байна. Үүнд «А Кыогийн үнэн түүх», «Галзуу хүний өдрийн тэмдэглэл», «Уриа» зэрэг зохиолыг тухайлан дурдаж болно. Лу Синь түүхэн том үйл явдлыг хувь хүний амьдралын жижиг үзэгдлээр дамжуулж харуулахдаа гарамгай зохиолч билээ.

Лу Синий онцгой уран чадварын нэг илрэл бол түүний туурвисан олон тооны нийтлэл зохиол юм. «Хятадын Их цагаан хэрэм» хэмээх ганцхан тал хуудас нийтлэлдээ ямар их санаа агуулсныг жишээ татан үзье. Түүнд; «...Нүүдэлчдийн довтолгооноос энэ хэрэм Хятадыг хамгаалж байсан юм гэж үү!? Хэдэн зууны турш энэ хэрмийг овоолох гэж ер хичнээн ч хүнийг хий дэмий тарчилгаж үгүй болгоо юм бэ?! ...Шинэ туйпуун нөхөөстэй хуучин энэ хэрэм даян дэлхийн нүднээс миний ард түмнийг нуужээ. Намайг ч ялгалгүй зүг бүрээс бүсэлчихээд амьсгаа давхцуулж байна! ...Гэтэл энэ хэрмийг хадгалж хямгадах гэх хүн бас байх юм! ...Түмэн газрын Их хэрмийг босгосон зүйл гэвэл эртний тоосго бөгөөд энд тэнд шинэ цагийн туйпуугаар нөхсөн нь харагдана. Их хэрэмд шинэ тоосго нэмэхээ болих цаг хэзээ ирэх юм бэ?! Аяа, аугаа их атлаа амьтны хараал идсэн нүдэнд хүйтэн их хэрэм!!!»<sup>20</sup> гэж бичжээ.

Урагшлах хөдөлгөөнд саад тавигч бэртэгчин хүмүүстэй хайр найргүй тэмцэх явдлаар Лу Синий хувьсгалч чанар илрэх нь олонтой. «Байлдааны талбарт бол цэргийн эмч хийх, хувьсгалд бол ар талд явах, хүн-амины хэрэгт зандалчилах-энэ бүхэн баатар хэмээгдэхэд ч амархан, бас амиа хоохойлоход ч буйртай арга мөн»<sup>21</sup> гэж тэр бичиж байв.

Хятадын утга зохиолын түүхийг судалсан нь түрүү үеийн хүмүүсийн хөндөөгүй атар газрыг хагалсантай зүйрлэм цоо шинэ, нөр их ажил байлаа. Үүний зэрэгцээгээр Лу овогт бичгийн их хүн Байрон, Пөтөөфи, Бальзак, Мицкеевичээс суралцаж,<sup>22</sup> тэдний бүтээлийн дээжсээс цэцгийн бал түүх ажилч зөгий лугаа адил уйгагүй, түүвэрлэн орчуулсан нь хойд

<sup>19</sup> Лу Синь. собр .соч. в 4-х томах, под ред. В. С. Колоколова, К. М. Симонова, Н. Т. Федоренко, Т. II, Госполитиздат, 19-55, с. 9

<sup>20</sup> Лу Шинь. Мөнх гийгч дэнлүү (өгүүллэгүүд), БНМАУ, ХХЭ хороо, УБ, 1962, 5,1 дүгээр тал. Лу Синь Рассказы и статьи, ГИХЛ., М., 1950, стр 71.

<sup>21</sup> Хятад дахь хэрэг явдал (1963-1973),- I УХГ, УБ., 1974, 269 дугаар тал.

<sup>22</sup> Мөн тэнд.

үеийн зохиолчдод дууриалтайн дээр хятадын шинэ цагийн хувьсгалт утга зохиолын хөгжилтөд тодорхой холбогдол бүхий том хувь нэмэр болжээ.

Орос, зөвлөлтийн утга зохиолыг судлах, сурталчилахад Лу Синь тийм ч урт биш амьдралынхаа олон хоногийг зориулж, Толстой, Лермонтовын бүтээлүүдээс орчуулж, Пушкиний уран бүтээлийн тухай өгүүлүүд бичсэн билээ, «Дөлгөөн Дон»-ы тэргүүн ботийг хятадаар хөрвүүлж, их Горькийн зохиолын гүнд нэвтэрч чадахуйцаар орос хэлийг сурч амжаагүйдээ харамсаж харуусаж байв. «Миний бие Зөвлөлтийн утга зохиолын ихэнхийг Хятадад танилцуулах бодолтой. Шинэ цагийн Хятад оронд хувьсгалч дайчин агуулгатай зохиол онц хэрэгтэй байна<sup>23</sup> гэж Лу Синь тунхагласан юм.

Лу Синь «Урлаг, урлагийн төлөө» гэдэг харгис үзэл номлогчдыг эсэргүүцэж, соёлын өв дурсгалыг сүйтгэгчидтэй хатуу ширүүн тэмцэхийг эрхэм дээд үүргээ хэмээн үзэж байлаа. Зөвхөн хятадын төдийгүй, хүн төрөлхтний хуримтлуулсан соёлын аугаа их галиварбаасан модыг нандигнан хамгаалж, тэр модыг тэжээж, тэр модноос тэжээл авч байхыг Лу Синь хятадын соёлын төлөөлөгчдийн хойч хойчийн үед мартахын аргагүйгээр захижээ. Түүний бичсэн нь: «...Хувьсгалд зайлшгүй эвдэх чанар бий. Гэхдээ хамгийн чухал нь бүтээн байгуулах явдал юм. Эвдлэх ажил хялбар тул түргэн гавшгай гүйцэтгэж болмой. Харин хувьсгалчаар бүтээн байгуулах нь түвэг ихтэй шүү...»<sup>24</sup> гэсэн билээ. Энэ үг хятадын хувьсгалчдын олон үеийг хүмүүжүүлсэн хийгээд Хятадад ардын засаг ялсны эхний жилүүдэд Лу Синий үзэл санаа амьдран хэрэгжих шимтэй хөрс хятадын нийгэмд бүрэлдэн тогтож байлаа.

Гэвч хятадын хувьсгалт хүчний доторхи хоёр шугамын тэмцэлд маоист үндсэрхэг дээрэнгүй чиг бодлого түр давамгайлж, «Пролетарийн соёлын их хувьсгал» гэгч эмгэнэлт явдал гарсныг Лу Синий соён гийгүүлэгч үзэл бодлыг талархагч бүхэн, хятадын ард түмний сайн санаат нөхөд болгон, хятад үндэстний соёлын түүхийн тэмдэглэлт энэ өдрүүдэд харуусгалтайгаар нэхэн дурсахгүй байж болохгүй билээ. «Соёлын хувьсгал» гэгч Лу Синийг таалал төгссөнөөс хойш яг 30 жилийн дараа эхэлжээ. Гэвч: Мао Зэдуны турхиралтаар «соёлын хувьсгалыг» хийгчид болоод Ленин, Горький, Шолоховыг төрүүлсэн ЗХУ-ыг эн тэргүүн дайсагнаж, зөвлөлтийн эсрэг үзлээр бамбай барин империалистуудтай сүлбэлдэж байгаа Бээжингийн эрх баригч бүлэгтэй хятадын ард түмний сод хүү Лу Синь өнөөдөр ч тэмцэл хийсээр бидний эгнээнд явсаар байна.

xx xx xx

Лу Синий төрсний 100 жилийн ойг БНХАУ-д нилээд өргөн тэмдэглэж, Бээжинд Лу Синий үйл амьдрал, уран бүтээлд зориулсан эрдэм шинжилгээний бага хурал хийжээ. Гэхдээ энэ ойг бээжингийн одоогийн эрх баригчид өөрсдийн зорилгод ашиглах санаа өвөрлөсөн нь илт байна. Хятадын нийгмийн ухааны академийн дэд ерөнхийлөгч Мэй И бага хурлыг нээж хэлсэн үгэндээ «Хятадын Лу Синь судлалын онолын үндсийг Мао Зэдун «Шинэ ардчилал» гэдэг зохиолдоо суурлиулан тавьсан»<sup>25</sup> мэтээр тэмдэглэсэн нь анхаарал татаж байна. Мао 1939 онд бичиж, 1940 оны эхээр хэвлүүлсэн «Шинэ ардчилал» бол марксист хятад судлаачдын үзэж, нотолж байгаагаар «Ленинизмд дайн зарласан» өгүүлэл бөгөөд гол санаа нь ленинизмийн интернационалч чанарыг үгүйсгэж «марксистыг хятадчилахыг» номлоход чиглэгджээ. Хятадын их гүрний үнд-

<sup>23</sup> Мөн тэнд.

<sup>24</sup> «Хятад дахь хэрэг явдал» 270 дугаар тал.

<sup>25</sup> «Жэньминь жибао» 1981 оны IX сарын 18.

сэрхэг үзэлт Мао Зэдун «Хятадын онцгой байдлын тухай» онолоо зөвтгөхийн тул хятад хүний нь хувьд Лу Синий нэр хүндийг хортойгоор ашиглахыг оролдсон юм. Гэвч өнөөдрийг хүртэл интернационалч Лу Синий зохиол бүтээлийн мөр хуудас бүхэн нь үндсэрхэг маоист үзэл санаанд няцаалт өгсөөр байна. Биеэ «коммунист», «марксист» гэж нэрлэх нь олонтаа байдаг Мао болон түүнээс хойших хятадын удирдагчдад зориулсан мэт Лу Синь: «өөрөө өөрийгөө ариун шударга гээд байгаа хүнээс л болгоомжлох хэрэгтэй. Тийм хүн ёстой луйварчин байдаг юм шүү!» гэж алдарт цоохор тэмдэглэлийнхээ нэгэнд дурджээ.<sup>26</sup>

Их гүрний дээрэнгүй үзэл бодолдоо түүхийг захируулах гэж оролддог байсан Чан Кайши нарын хуучин арга барилыг маогийнхан өвлөн ашиглаж, хэрхэн «хөгжүүлж» байгаа нь нийтэд илэрхий билээ. Лу Синь 1934 онд: «Манай» Чингэс хаан Европыг байлдан дагуулсан зуун бол «манай» түүхийн алтан үе байлаа гэж ярилцахыг би 20 насандаа сонссон. Дөнгөж 25 хүрч байж, чухам «манай» түүхийн тэр алтан үе гэгчийн өнгөнд монголчууд хятадыг дайтан эзэлж, бид боолын тавилан амсах болсныг ойлгож билээ»<sup>27</sup> гэж бичээд ...Монголчууд бүх хятадыг байлдан эзлэхээсээ өмнө «Оросыг» дайлж, Венгри Австрид нэвтэрсэн хийгээд тэр үед Чингэс хаан «манай хаан байгаагүй юм. Оросууд манайхаас түрүүнд бутран хуваагдсан. Ийм болохоор чухам тэд л: «манай Чингэс хаан хятадыг байлдан дагуулсан тэр үеэр манай түүхийн алтан үе эхэлсэн гэж хэлэх ёстой билээ»<sup>28</sup> хэмээн гүн ёгтлолтойгоор тэмдэглэжээ.

Түүх засварлагч гоминданыханд өгсөн их зохиолчийн энэ няцаалт манай эх орны эсрэг олон жилийн турш газрын зураг зүйн болон түүхийн түрэмгийлэл үйлдэж байгаа хятадын маоист удирдагчдыг давхар яллаж байна.

## ЛУ СИНЬ-ОСНОВОПОЛОЖНИК РЕВОЛЮЦИОННОЙ КИТАЙСКОЙ ЛИТЕРАТУРЫ

**Д. Маам**

Статья посвящена 100-летию со дня рождения выдающегося представителя китайской литературы и общественной мысли Лу Синю.

Родившийся в семье разорившегося деревенского землевладельца на китайской окраине маньчжурской цинской империи, Лу Синь вырос в великого деятеля литературной мысли, основоположника новой революционной китайской литературы.

В. И. Ленин, рассматривая развитие китайского общества того времени, охарактеризовал его как «переход старых китайских бунтов в сознательное демократическое движение»<sup>1</sup>. Лу Синь жил в период такого «перехода» и собственными глазами видел поражение Ихэтуаньского восстания в 1901 году, вторжение в его страну войск восьми иностранных государств, годы революционного подъема, и все это сыграло важную роль в формировании мировоззрения молодого Лу Синя.

<sup>26</sup> «Мөнх гийгч дэнлүү» 121 дүгээр тал.

<sup>27</sup> Лу Синь, Зохиолууд. VI боть. Бээжин. 109 дүгээр тал. (хятадаар) Ш. Бира, Н. Ишжамц, Ш. Сандаг «Маоистская фальсификация истории МНР и историческая правда» (Госиадат, УБ., 1980) номноос дамжуулж ишлэл татлаа.

<sup>28</sup> Мөн тэнд.

<sup>1</sup> В.И. Ленин. Соч. Т. 15, стр. 162.

На окончательное идейное формирование Лу Синя решающее влияние оказала Великая Октябрьская социалистическая революция. Лу Синь писал: «Русская литература раскрыла перед нами прекрасную душу угнетенного, его старания, его борьбу...Мы поняли самое важное, что существуют два класса-угнетатели и угнетенные!...Тогда это явилось величайшим открытием, равным открытию огня...»<sup>2</sup>.

Сближение с коммунистическим и рабочим движением Китая позволило Лу Сину еще глубже проникнуть в сущность классовой борьбы, прийти к правильному пониманию истории человеческого общества.

Великий китайский писатель не только в высочайшей мере сознавал, понимал значение революции, но и был ее пламенным певцом и глашатаем. «...Это естественно, что революционирующие нации, выражая интенсивное сопротивление и раскрывая скрытые в них огромные ресурсы, меняют жалобные песни на рокот затаенного гнева...так литература, несущая искры гнева, и революция взаимно развивают друг друга... Такая литература родилась в предвестии революции в Советской России».<sup>3</sup>

Реализм Лу Синя выражается в осознании им светлых идей грядущего социализма. Именно это сознание-наивысшая из многих высот, достигнутых писателем в его творчестве.

<sup>2</sup>Лу Синь. Собр. соч. в 4-х томах, под ред. В. С. Колоколова, К. М. Симонова, М. Т. Федоренко, Т. П. Госполитиздат, 1955, стр. 99.

<sup>3</sup>Лу Синь. Мөнх гийгч дэнлүү. УБ., 1954, 55—56 дахь тал.